

ӨМНӨХ ҮГ

МУИС-ийн Эдийн Засгийн Сургуулиас эрхлэн гаргадаг “ЭДИЙН ЗАСАГ: онол, практик” сэтгүүлийн 23 дахь дугаарыг Та бүхэндээ толилууулж байна.

Энэ дугаарт нийтлэгдэж байгаа өгүүлүүд нь макро, микро эдийн засаг, менежмент, маркетинг, эконометрикийн салбар дахь сонирхолтой бөгөөд шийдвэр хүлээгдэж буй асуудлуудыг авч үзсэнээрээ онцлог юм.

Нийтлэгдэж байгаа өгүүлэл бүр Монголын эдийн засагт тулгамдаж байгаа олон асуудлуудаас тодорхой сэдвийг сонгон онолын үндэслэлийг гаргаж тавихын зэрэгцээ практик амьдралд үр ашигтай шийдвэрлэх арга замыг тодорхойлж байгаагаараа онол, практикийн ач холбогдолтой юм. Тухайлбал, макро түвшинд “Дэлхийн санхүү, эдийн засгийн хямралыг даван туулахад зүүн хойд азид Монгол улсын гүйцэтгэх үүрэг” гэсэн өгүүлэл нь олон улсын түвшинд Монгол улсын гүйцэтгэх үүргийг тодорхойлсон бол “Мянганы хөгжлийн зорилтууд, тэдгээрийг дүгнэх үзүүлэлтүүд: олон улсын стандарт ба манай орны практик” өгүүлэлд мянганы хөгжлийн зорилтуудыг манай оронд дүгнэж байгаа зарим үзүүлэлтийг олон улсын стандарт ойлголт, тодорхойлолт, тооцох аргачлалд нийцүүлэн өөрчлөх шаардлагатай байгааг хөндөж тавьснаараа практик ач холбогдолтой болжээ.

Сэтгүүлийн чанар чансааг сайжруулах талаар өөрсдийн санал зөвлөмжийг ирүүлэхийг хүсэхийн ялдамд та бүхэндээ шинэ онд амжилт бүтээл арвин байхын өлзийтэй ерөөлийг өргөн дэвшүүлж байна.

Академич П.Лувсандорж
Профессор Б.Сувд

ЗОХИОГЧИД

1. **Б.Батмөнх.** Доктор(PhD)МУИС-ЭЗС-ийн Статистикийн тэнхимийн эрхлэгч, Судалгааны чиглэл: “Макро болон шилжилтийн эдийн засаг” бүтээл: “ Эрэлтийг дэмжиж л хямралаас гарна” ЭЗ-ийн онол,практик сэтгүүл 2008 он №21
2. **Д.Моломжамц.** Доктор (Sc.D),профессор МУИС – ийн ЭЗС – ийн $\Gamma \Delta \Delta \epsilon \epsilon \Gamma \delta \gamma \beta \alpha \delta \epsilon \Gamma \delta \delta \alpha \delta \delta$. Судалгааны чиглэл нь: Хөрөнгө оруулалтын шинжилгээ. Бүтээл “Хөрөнгө оруулалт” 2008 он
3. **Б.Энхмаа.**Дэд профессор, МУИС-ЭЗС-ийн Менежментийн тэнхимийн багш. Судалгааны чиглэл: “Бизнесийн төлөвлөлтийг боловсронгуй болгох” Сүүлийн бүтээл “Чингис хаан” нисэх буудлын бизнес төлөвлөгөө,”Дэлхийн буддын сургалтын төвийн судалгаа”.
4. **Д.Баяржаргал.** МУИС-ОАСС-ийн санхүүгийн тэнхимийн багш, докторант “Судалгааны чиглэл ”Макро эдийн засаг
5. **Д.Чүлтэм.** МУИС-ЭЗС-ийн докторант. Судалгааны чиглэл: “Монгол улсын газрын эдийн засгийн үнэлгээ”Сүүлийн бүтээл: ЭЗ-ийн онол практик сэтгүүл УБ.2008 №299(19)
6. **Н.Лизунов.** Дэд профессор МУИС-ЭЗС-ийн Менежментийн тэнхимийн багш. Судалгааны ажлын чиглэл нь “Үйлдвэрлэлийн менежмент”.
7. **С.Бурмаа** МУИС-ЭЗС-ийн докторант ”Жижиглэн худалдааны барааны нөөцийн удирдлага”
8. **Б.Нарантуяа.** МУИС-ЭЗС-ийн докторант. Евро-Ази Дээд сургуулийн багш. Судалгааны чиглэл:”Монгол орны зар сурталчилгааны менежментийг боловсронгуй болгох нь. ”Сүүлийн үеийн бүтээлээс“20-р зууны эхэн үеийн монголчуудын хэрэглээ“ ЭЗ-ийн Онол практик сэтгүүл УБ.2008 №290(18)
9. **Б.Ган-Очир, П.Авралт-од, Б.Даваадалай.** Монголбанкны мөнгөний бодлого, судалгааны газрын мөнгөний бодлогын хэлтсийн эдийн засагч.
10. **Б.Энх-Амгалан.** Доктор(PhD), МУИС-ЭЗС-ийн статистикийн тэнхимийн багш. Судалгааны чиглэл: “Үндэсний тооцооны системийн асуудлууд, ЭЗ-ийн өсөлт”. Бүтээл: “Боловсролын болон орлогын ялгаанаас үүдэлтэй шилжих хөдөлгөөн ба эдийн засгийн өсөлт” ЭЗ-йн онол: практик сэтгүүл 2008.№290(18)